



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, жуулчны  
баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эм эм эм ди ХХК-ний “Кайзер” зочид буудлын 13/108, Жи эн и дабль юу ХХК-ний “Хан” зочид буудлын 17/007, Магт капитал ХХК-ний “Арт апартамент” зочид буудлын 15/111, гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500043

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 02 сарын 22 өдрийн А/ндугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ


2018.02.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Залуучууд зочид буудал ХХК	2120259	Залуучууд	СБД-ийн 6-р хороо бага тойруу 43
2	Эм эм эм ди ХХК	5115183	Кайзер	СБД 1-р хороо ЭТӨЧ 10/2в
3	Их сүлд групп ХХК	2747332	Амгалан	БЗД-ийн 10-р хороо Улиастайн гудамж өөрийн байр
4	Дөрвөн луу ХХК	2078678	Этүгэн	СХД-ийн 29-р хороо москва хороолол 18073
5	Магт капитал ХХК	5622352	Арт апартамент	ХУД-ийн 11-р хороо Ар зайсангийн гудамж 91/1-402
6	ТТИ ХХК	6017592	Гоулд мүүн	НД-ийн 2-р хороо Дамдины гудамж 86/1

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 02 сарын 22-  
өдрийн А/М дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.02.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Би эс ти жи ХХК	5496098	Эс жи	СХД-ийн 4-р хороо их наран 1-225
2	Даян хаан индастри ХХК	5977207	Даян	ЧД-ийн 9-р хороо Дэнжийн 1-0066

--ooOoo--